

**“СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ХАРИЛЦАА”
СЭДЭВТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЙЛАН**

2019.03.18

Тайлангийн бүтэц: Тус тайлан нь сургалтын технологийн тогтолцооны дагуу орц, явц, гарц гэсэн бүтэцтэй. Сургалтын тайланг бичихдээ PDCA чанарын менежментийн арга, төлөвлөлттэй байх, зорилгод хүрэх чанартай үйл ажиллагаа, үр ашигтай тасралтгүй хөгжих, үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлах зарчмуудыг удирдлага болгов. Түүнчлэн багшийг сургалт болон практик үйл ажиллагааны явцад тасралтгүй хөгжүүлэхэд анхаарч, цаашид сайжруулах боломж, арга замын асуудалд ач холбогдол өгсөн болно.

Тайлангийн арга зүй: PDCA зарчим “Демингийн цикл”-ээр төлөвлөх, хэрэгжүүлэх хянах, сайжруулах гэсэн 4 бүтцээр дүн шинжилгээ хийсэн.

Тайлангийн ач холбогдол: Зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааны чанар, цаашид шийдвэрлэх боломж, арга зам, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход хувь нэмрээ оруулна. Сургалтын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, таниулах, сурталчлах, сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах зорилгод нийцнэ хэмээн авч үзсэн болно.

Тайлангийн агуулга:

Үе шат	Агуулга		Хуудас
Нэгдүгээр хэсэг-Орц Plan- Төлөвлөх	Сургалтын зохион байгуулалт	1.1 Сургалтын хэрэгцээ,шаардлага 1.2 Сургалтын төлөвлөгөө 1.3 Сургалтын бэлтгэл ажил	2-4
Хоёрдугаар хэсэг- Явц Do- Хэрэгжүүлэх	Сургалтын хэрэгжүүлэлт, явц	2.1 Сургалтын зохион байгуулалт 2.2 Сургалтын агуулга 2.3 Сургалтын багийн бүрэлдэхүүн	4-6
Гуравдугаар хэсэг- Гарц Check-Хянах Act- Сайжруулах	Сургалтын үр дүн,үнэлгээ	3.1 Сургалтын агуулга, хэлбэрийн үнэлгээ 3.2 Сургагч багш нар болон оролцогчдын хэрэгцээнд нийцтэй байдлын үнэлгээ 3.3 Сургалтыг сайжруулах боломж 3.5 Ерөнхий дүгнэлт 3.4 Хавсралт/фото зураг/	7-11

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ-ОРЦ СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Сургалтын хэрэгцээ, шаардлага:

Багш нарт хүүхэд бүрийг мэдэрч, ойлгож, хүндэтгэж харилцах хандлагыг төлөвшүүлж, хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй эзэмшихэд дэмжлэг зайлшгүй шаардлагатай тухай “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого” (2013)-д тусгагдсан. Багш бүхэнд өөрийн мэдлэг, ур чадвараа цаг ямагт дээшлүүлэх, сургалтын практик үйл ажиллагаанд туршин нэвтрүүлэх, бүтээлчээр хэрэгжүүлэх, өөрийгөө хөгжүүлэхээс гадна дараах чадамжуудыг бий болгох хэрэгцээ үүсэж байна. Үүнд:

Хүснэгт -1 Багшийн цогц чадамж

Академик чадамж	Судалгааны чадамж	Сургалтын хөтөлбөрийн чадамж
Харилцааны чадамж	Сэтгэл хөдлөлийн чадамж	Нийгэм соёлын чадамж
Тасралтгүй суралцах чадамж	МХХТ-ийн чадамж	Хүрээлэн буй орчны чадамж

Эх сурвалж: МУБИС, 2009 Багш мэргэжлийн стандартын харьцуулсан судалгаа

Судлаачид (Мөнхтуяа.Л,2014) дээрх чадамжуудыг багш нарт төлөвшүүлэхийн тулд дараах сурах аргад сургах хэрэгтэй хэмээн үзсэн байдаг.

-*Судлах* (Туршлагаар хэрэгтэй зүйлээ илрүүлж чаддаг, эзэмшсэн мэдлэгийнхээ хоорондын харилцан уялдаа холбоог тогтоож ашигладаг, асуудлыг шийдвэрлэдэг, бие даан суралцдаг гэх мэт.)

-*Хайх* (Төрөл бүрийн мэдээллийн санг ашигладаг, хүрээлэн буй орчноос хэрэгцээт мэдээллийг оновчтой сонгон авч ашигладаг, хүлээн авсан мэдээллийг ангилан төрөлжүүлж боловсруулдаг гэх мэт.)

-*Бодох* (Өнгөрсөн болон одоогийн үйл явцын хоорондын хамаарал, харилцан холбоог тогтоодог, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал дахь өөрийн болон бусдын үйлдэлд дүгнэлт хийдэг, өөрийн санал бодлыг үндэслэлтэй, тодорхой зөв илэрхийлдэг, тавигдсан асуудлыг тал бүрээс нь задлан шинжилсний үндсэн дээр шийдвэр гаргадаг, гаргасан шийдвэр болон гүйцэтгэлд дүн шинжилгээ хийдэг гэх мэт.)

-*Хамтран ажиллах* (Багийн зохион байгуулалтаар хамтран ажиллаж шийдвэр гаргадаг, бусдын санал бодлыг хүндэтгэлтэйгээр хүлээн авдаг, өөрийн санал бодлыг

үндэслэлтэй, тодорхой зөв илэрхийлдэг, мэдээлэл ба мэдлэгийг бусадтай хамтран бүтээж, эзэмшдэг гэх мэт.)

-*Ажил хэрэгч байх* (Хувийн ажлыг оновчтой төлөвлөдөг, асуудалд бодитой байр сууринаас хандах, хариуцлага, ёс суртахуунтай, ганцаарчлан болон багаар ажиллах чадвартай гэх мэт.)

-*Дасан зохицох* (Нөхцөл байдалд зохицон ажилладаг, суралцах үйл ажиллагаандаа МХХТ-ийг сонгон ашиглаж чаддаг, асуудлыг шийдвэрлэх боломжит арга замуудыг тодорхойлж, тэдгээрээс хамгийн оновчтойг нь сонгон хэрэгжүүлж чаддаг гэх мэт.)

Дээрхээс дүгнэн авч үзвэл орчин үеийн боловсролд зөвхөн нэг талыг барьсан чадварыг бус, бүх чадварыг нэгэн зэрэг хөгжүүлж чадах сургалтыг зохион байгуулах шаардлага гарч байна. Иймээс бид дээрх хэрэгцээнд нийцсэн болон хүүхэд бүрийг хөгжүүлэх сургалтын технологийг эзэмшүүлэх, багшлах арга зүйд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, мэргэжлийн тусгай дидактикийн ур чадварт суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилготойгоор энэхүү сургалтыг зохион байгуулах үндэслэл болсон юм.

1.2 Сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө

НБГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу төрийн өмчийн цэцэрлэгийн багш нарт зориулсан “Сурган хүмүүжүүлэх харилцаа” сургалтыг дараах бүтэцтэйгээр зохион байгуулахаар төлөвлөсөн.

- Хамрах хүрээ: Төрийн өмчийн 213 цэцэрлэгийн бүлэг хариуцсан 2262 багш
- Зохион байгуулах хугацаа: 2019 оны 02 дугаар сарын 16-аас 03 дугаар сарын 23 хүртэл
- Сургалтын агуулга: Багш, эцэг эхээс хүүхэдтэй харилцах харилцааны онцлог, бага насны хүүхдийг нийгэмтэй харилцах харилцаанд сургах арга зүй
- Сургалтад тавигдах шаардлага: Суралцах үйл ажиллагааг оролцогч төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сургах, идэвхтэй арга хэлбэрийг зохистой хослуулсан байх
- Хамтран зохион байгуулагч байгууллагууд: Дүүргүүдийн Боловсролын хэлтэс, “Хүүхэд зорчиж байна” ТББ, Санитас-50 хөтөлбөр

1.3 Сургалтын үйл ажиллагааны бэлтгэл ажил:

“Сурган хүмүүжүүлэх харилцаа” модуль сургалтын бэлтгэл ажлыг:

1. “Зан чанар, харилцаа” суралцахуйн чиглэлийн тусгай чадварыг бага насны хүүхдэд эзэмшүүлэхэд багшид дэмжлэг үзүүлэхүйц агуулгыг боловсруулах;

2. Сонгосон агуулга, арга зүйг харгалзсан сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрэглэх ба нэр төрөл, хүртээмж нь зохистой байх;
 - Сургалтын хэрэглэгдэхүүн нь сэтгэл зүй, жендер, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагад хангасан байх;
 - Сургалтын хэрэглэгдэхүүнийг олон хувилбараар ашиглах арга зүйг түгээн дэлгэрүүлсэн байх;
 - Товьёг тэмдэглэл хийж ашиглахад хялбар тодорхой болгосон байх зэрэг зарчимд суурилсан байхуйцаар хийсэн болно.

Хүснэгт-2 Сургалтын хэрэглэгдэхүүний нэр, төрөл


Хэрэглэгдэхүүний нэр, төрөл	Агуулга	Төрөл	Тоо ширхэг
Сургах зүйн	“Зан чанар харилцаа” сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд ашиглагдах хувилбар загвар	3	36
Техник болон МХТ-д тулгуурласан	Мультимеда үзүүлэн, видео бичлэг, цахим үзүүлэнгийн загвар	4	8
Хэвлэмэл	Тоглоомын хувилбарт хэрэглэгдэх карт, тараах материал, дэлгэмэл ном, соронзот үзүүлэн	12	250
Нийт		19	293

ХОЁРДУГААР ХЭСЭГ- ЯВЦ СУРГАЛТЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ЯВЦ

2.1 Сургалтын зохион байгуулалт

2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээлэлийн үндсэн багшийн тооноос биеийн тамир болон хөгжмийн багш нарыг хасалгүйгээр 2262 орчим багшийг сургалтад оролцуулахаар тооцсон. Харин сургалтад зөвхөн 1968 бүлгийн багшийг оролцуулсан нь хамрагдвал зохих багш нарын 88%-ийг эзэлж байна.

Зураг 1 Сургалтад оролцогчдын тоон мэдээлэл



Сургалтад оролцсон багш нарын ерөнхий мэдээлэл:

Зураг -2 Оролцогчдын ажилласан жил



Төрийн өмчийн цэцэрлэгт ажиллаж байгаа багш нар бага насны хүүхэдтэй ажиллах практик үйл ажиллагаанд илүү их суралцсан байх магадлалтай нь сургалтын чанар болон хэрэглээнд эерэгээр нөлөөлж болох талтай юм.

2.2 Сургалтын агуулга:

Сургалтын агуулга нь “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийн “Зан чанар, харилцаа” суралцахуйн чиглэлийг зохион байгуулахад мэргэжил арга зүйд дэмжлэг үзүүлэхүйцээр боловсруулагдсан.

- Зан чанар, харилцаа сургалтын зорилго, зорилт
- Зан чанар, харилцаа сургалтын агуулга
- Зан чанар, харилцаа сургалтын арга зүй
 - Зан чанар, харилцаа сургалтын зохион байгуулалтын хэлбэр, арга
 - Зан чанар, харилцаа сургалтын орчин/хэрэглэгдэхүү
 - Зан чанар, харилцаа сургалтын үйл ажиллагааны хувилбарууд

Сургалтын агуулгын хувьд хөтөлбөр нь үр дүнд чиглэсэн, агуулга, арга зүйн хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйд олон талт арга хэлбэрийг тусган хэрэгжүүлсэн. Сургалтад төсөлт ажил, багаар ажиллах чадварыг дээшлүүлэхэд анхаарч идэвхтэй арга хэлбэрүүдийг ашигласан нь оролцогчдын сонирхлыг өдөөж, үр дүнгээ өгсөн. Сургалтыг зохион байгуулахдаа ашигласан аргуудыг тодруулан авч үзэхэд багшийн сургах арга, түүний хэрэглээ олон талтай байгааг харж болно.

Хүснэгт -3 Сургалтад хэрэглэгдсэн аргууд

№	Үе шат	Сургалтад хэрэглэгдсэн аргууд
1	Сэргээх	Харилцан яриа, Маргаан, мэтгэлцээн, Марафон бичлэгийн арга

2	Ойлгох	Лекцийн арга, Боловсронгуй лекцийн арга, Бүтээлч асуултын арга
3	Хэрэглэх	Асуулт бэлтгэх, Оюуны довтолгоо
4	Задлан шинжлэх	KWL, INSERT
5	Дүгнэх	Хоршин суралцах арга, Сүүлчийн үгийг өөрт нь үлдээх арга
6	Бүтээх	Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, Программчилсан сургалт

2.3 Сургалтыг зохион байгуулагч багийн бүрэлдэхүүн

Сургалтын багийн бүрэлдэхүүн нь сургагч багшаар бэлтгэгдсэн, боловсрол, мэргэжил мэдлэг, хувь хүний сонирхол, хувийн соёл, зан харилцаа, хүнтэй ажиллах эв дүй, нийгмийн идэвх, багаар ажиллах чадвар, хөдөлмөрийн чадвар чадамж, ажил хэрэгч чанар зэрэг үзүүлэлтээр хүлээн зөвшөөрөгдсөн.

Хүснэгт-4 Сургагч багш нарын ерөнхий мэдээлэл

Багийн бүрэлдэхүүн	Мэргэжил	Хамтран боловсруулсан сургалтын модуль, хөтөлбөрийн тоо	Хамтран боловсруулсан ном, бүтээл гарын авлагын тоо	Хамтран ажилласан төсөл, хөтөлбөрийн тоо	Хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн илтгэл өгүүллийн тоо
Х.Алтанхундага	Багш, СӨНБ	6	6	5	10
Ц.Эрдэнэчимэг	Багш, СӨНБ	8	8	10	5
		14	14	15	15


Сургагч багш нар нь сургалтын зорилго зорилтыг хангахуйц, онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн, эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн ур чадвартай, үндэсний хэмжээний сургалт, судалгааны багт орж ажиллаж ирсэн нь салбартаа хүлээн зөвшөөрөгдөж байгааг харуулах нэг үзүүлэлт гэж үзэж байна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ- ГАРЦ СУРГАЛТЫН ҮР ДҮН, ҮНЭЛГЭЭ

Сургалтын үйл ажиллагааг нэг талаас оролцогчдоор үнэлүүлэх, сургалтыг үр дүнг тодорхойлох, нөгөө талаас багш өөрийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийж сургалтын үйл ажиллагаагаа сайжруулах, цаашид анхаарч ажиллах шаардлагатай асуудлыг илрүүлэх зорилгоор үнэлгээг авсан болно. Сургалтын санал асуулгад оролцогчдын 97% нь оролцсон бөгөөд нэгтгэлийг авч үзвэл:


3.1 Сургалтын агуулга, хэлбэрийн үнэлгээ

Зураг -3 “Зан чанар, харилцаа” суралцахуйн чиглэлээр сургалтад хамрагдсан байдал



Бүлгийн багш нарын 57% нь анх удаа энэ чиглэлийн сургалтад хамрагдсан нь тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн, багшийн дидактик тусгай ур чадварын хөгжлийг дэмжсэн анхны сургалт болсноороо давуу талтай болсон, мөн дүүрэг бүрийн багш нарын сургалтад хамрагдсан байдал харилцан адилгүй, өөр өөр байгааг харж болно.

Зураг -4 Сургалтын хөтөлбөрийн агуулга нь хэрэгцээг хангасан байдал




Сургалтын хөтөлбөрийн агуулгын хэрэгцээт байдлыг ихэнх буюу 85.0% нь “Бүрэн хамарч чадсан” гэж үзсэн нь сургалтын зорилго, үр дүнд эерэгээр нөлөөлж буй нь харагдаж байна.

“Бага зэрэг хамарсан” гэж үзсэн оролцогчид нь илүү ихээр судлах болсон хэрэгцээг ч харуулж байх магадлалтай юм.

Зураг-5 Сургалтын зохион байгуулалтын хэлбэр

Сургалтын зохион байгуулалтын хэлбэр




- Лекц давамгайлсан
- Бүлгээр ажиллах хэлбэр давамгайлсан
- Хэлэлцүүлэг давамгайлсан
- Онол-дадлага хосолсон
- Харилцан ярилцах давамгайлсан
- Тэргүүн туршлагаас танилцах

Сургалтад төлөвлөгдсөн олон талт хэлбэр, аргуудыг ашигласан байдал харагдаж байгаа бөгөөд оролцогчдын 64,0 % нь “Онол-дадлага хосолсон” гэж үзсэн нь сургалтын төлөвлөлт, зохион байгуулалт хоорондоо нийцтэй явагдсаныг харуулж байна. Мөн сургагч багш нар нь зан чанар харилцааны чиглэлээрх онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн, сургалтын арга зүйн ур чадвартай байдал нь сургалтын хэлбэрт илүү нөлөөлсөн байх талтай юм.


3.2 Сургагч багш нар болон хэрэгцээний үнэлгээ

Зураг -6 Сургагч багш нарын үйл ажиллагааг үнэлсэн байдал



Дунджаар “Маш сайн” үнэлгээ 94% байгаа нь бидний өмнө дурдсанчлан багийн бүрэлдэхүүний чадамжтай холбон авч үзэх нэг үзүүлэлт нь ч болох юм.

Зураг-7 Сургалтад оролцогчдын сонирхлыг хамгийн их татсан, онцлог бүхий мэдээлэл




Дээрхээс дүгнэн үзвэл сургалтын бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг олон хувилбараар хийсэн арга зүй нь оролцогчдын хамгийн их сонирхол, хэрэгцээнд нийцсэн байна. Сургалтын дээрх үнэлгээнд үндэслэн авч үзвэл сургалт нь оролцогчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн, багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэхүйц ажил болсон гэж үзэж болно.

3.3 Сургалтыг сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг ашигласан байдал

Сургалтын үнэлгээ нь нэг талаас өнөөгийн үр дүнг тооцох, нөгөө талаас цаашид сайжруулах үйл ажиллагааны мэдээлэл болдог онцлогтой тул бид оролцогчдоос авсан асуулгыг ашиглаж, дараах байдлаар сайжруулалтыг хийж болно гэж дүгнэж байна.

Судалгаанд насны ангиллыг авч үзсэн нь байгууллагын удирдлагууд болон сургалтыг зохион байгуулагчид тухайн насны онцлогийг харгалзсан сургалтын хэлбэрийг хэрэгжүүлэхэд ихээхэн ач тустай хэмээн авч үзсэн болно.

Зураг-8 Багш нарын насны ангилал



Энэхүү сургалтад оролцогчдын хамгийн их буюу 30-39 хүртэл насны багш нар 40%-ийг, 40-49 хүртэл насны багш нар 38%-ийг эзэлж байгаа нь онцлог юм.

Дээрх насны ангиллын багш нарын онцлогийг судлаачдын (БМДИ,2016)

тодорхойлсноор авч үзвэл:

- 30-39 хүртэлх насны багш нар нь аливаа сургалтад хамрагдах дуртай бөгөөд урт хугацааны хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллахад үр дүнтэй байдаг;
- 40-49 хүртэлх насны багш нарын хувьд сургалтын тав тухтай орчинг бүрдүүлэх, ямар нэг чиглэлээр мэргэшсэн байх тул тодорхой дадлыг хөгжүүлэх чиглэлээр хамруулах нь зохимжтой байдаг байна.

Иймээс бид сургалтыг зохион байгуулахдаа сургалтын таатай орчинг бүрдүүлэхэд анхаарах, багшийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа дээрх онцлогуудыг цаашид судлан, харгалзан авч үзнэ.

Хүснэгт- 5 Сургалтад оролцогчдын хамрагдсан сургалтуудын чиглэлүүд
(Багш нарын хамрагдсан байдал давхардсан тоогоор)

	СӨБ.-ын сургалтын цөм хөтөлбөр	СӨББ-ын сургалтын орчны стандарт	Тэгш хамруулах боловсрол	Арга зүйн чиглэлийн сургалт	Хувь хүний хөгжил	Цахим хэрэглэгдэхүүн
БГД	349	371	270	337	156	106
БЗД	334	308	168	313	11	37
СБД	213	173	114	177	99	111
СХД	443	302	37	250	99	216
ХУД	138	78	53	93	47	53
ЧД	195	165	92	100	92	100
БНД	92	97	40	186	25	50
НД,БХД	59	59	45	62	50	45
Нийт	1823	1553	819	1518	579	718
Хувь	92%	79%	42%	77%	30%	37%

Сургалтад оролцогчдын хамгийн их буюу 92% нь “СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр” сургалтад оролцож ирсэн байна. Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих, тэдэнд туслах чиглэлд чухлаар тооцогдох болсон тэгш хамруулах боловсрол, арга зүйн чиглэлүүдийн сургалтад цаашид хамруулах талаар анхаарах нь зохистой юм.

Мөн бид цаашид ямар чиглэлийн сургалтад хамрагдах хэрэгцээ байгаа чиглэлээр авсан асуулгын үр дүнг нэгтгэвэл дараах дүр зураг харагдаж байна.

Хүснэгт -6 Цаашид зохион байгуулбал оролцох хүсэлтэй сургалтын чиглэл

Дүүрэг	СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр	СӨББ-ын сургалтын орчны стандарт	Тэгш хамруулах боловсрол	Арга зүйн чиглэлийн сургалт	Хувь хүний хөгжил	Цахим хэрэглэгдэхүүн
БГД	70	42	34	39	25	52
БЗД	88	73	19	95	5	41
СБД	70	18	15	60	24	31
СХД	88	37	11	101	14	87
ХУД	97	91	90	107	83	90
ЧД	95	98	92	100	92	104
НД,БХД	40	50	85	60	23	61
БНД	10	25	35	58	12	32
Нийт	558	434	381	620	278	498

Цэцэрлэгийн бүлгийн багш нар нь “СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр”, “Арга зүйн чиглэл”-ийн сургалтуудад хамрагдсан боловч дахин оролцох хүсэлтэй байгаа нь сургалтын агуулгаас мэргэжлийн заах арга зүйн чадвараа дээшлүүлдэг, ахисан түвшинд судлах сонирхолтой, ямар нэгэн чиглэлээр мэргэшсэн байх тул түүнийг ур чадвар болгон хөгжүүлэх сонирхолтой байдаг зэрэг онцлогтой холбоотой юм.

Гэвч ямар чиглэлийн сургалтад оролцох хүсэлтэй байгаагаа илэрхийлэхдээ тодорхой төлөвлөгөө болон өөрийн хэрэгцээний онцлогийг сайтар төлөвлөж байгаагүй нь сургалтын явцад өрнүүлсэн жижиг хэлэлцүүлгээс харагдаж байлаа.

3.4 Ерөнхий дүгнэлт

Бид сургалтын төлөвлөгөө, зохион байгуулалт, хүрэх үр дүнг тодорхойлсон агуулгын хүрээнд сургалт явагдсан гэж үзэж болохоор байгаа бөгөөд сургалтын орц, явц, гарцуудын дүгнэлтүүдийг нэгтгэн авч үзлээ. Тус сургалт нь оролцогчдын сонирхол хэрэгцээнд нийцсэн бөгөөд ерөнхийд нь дүгнэн авч үзвэл “Хангалттай” гэж үнэлж болох байна.

Цаашид сургалтыг зохион байгуулахдаа дараах онцлогийг харгалзах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийж байна. Үүнд

1. Цэцэрлэгийн багш, ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулахдаа зорилтот бүлгийг тодорхойлсон судалгааг авах;
2. Багшийн мэргэжил дээшлүүлэх хувийн төлөвлөгөөг боловсруулан түүний дагуу төрөлжсөн сургалтад оролцох боломжийг олгох;

3. Материаллаг орчноос гадна сэтгэл зүйн, үйлийн орчин нь сургалтын үр дүнд нөлөөлөх боломжтойг харгалзах;
4. Сургалтад оролцогчдод онолын мэдлэгээс илүү, багшийн практик үйл ажиллагаанд хэрэгжүүлэх арга зүйн чиглэлийн сургалтуудыг сонирхох зэрэг хэрэгцээ их байна.

Багшийн хөгжлийг дэмжих нэг чиглэл болох төрөлжсөн захиалгат сургалтуудад багш нар өөрсдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн байдлаар оролцох сонголтыг өргөжүүлэх, багш багшаасаа суралцах, суралцахуйн чиглэл тус бүрээр арга зүйн хувилбаруудтай танилцах нь үр дүнтэй болох бас нэг хувилбар гэж үзлээ.

ТАЙЛАН БИЧСЭН:

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
СӨБ, ЦЭЦЭРЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН 3. БОЛОРМАА